Мөнгөнморьт сумын Засаг дарга нь Засгийн газрын 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Аймгийн Засаг даргаас жилд 2 удаа бүх сум байгууллагад нэрэмжит үзлэг, Санхүүгийн хяналт аудитын алба удирдамж төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт явуулдаг, байгууллага бүрд дотоод хяналтын нэгж ажилладаг боловч сумын хэмжээнд төсөв санхүүгийн сахилга бат сайжирч, алдаа зөрчил буурахгүй байна. Цаашид анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөнгөнморьт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн тайлангийн санхүү үр дүнгийн нийт орлогыг суурь үзүүлэлтийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүү үр дүнгийн нийт орлогоос 1,5 хувиар буюу 50,656.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80,0 хувиар буюу 40,525.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүү үр дүнгийн нийт орлогоос тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөлтгүй байна

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг тооцоогүй болно.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсөвт байгууллага, төрийн сан, сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сан, эм эргэлтийн сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

Орлогын талаар:

Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн гүйлгээний тайланд аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 338,008.2 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжилт 1,154,836.3 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн сангийн санхүүжилт 91,612.7 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 9,522.9 мянган төгрөг, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 96,036.7 мянган төгрөг, Эм, эргэлтийн сангийн орлого 25,835.6 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 276,777.5 мянган төгрөг, орон нутгийн орлого 950,841.1 мянган төгрөг, нийт 2,943,471.0 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Мөнгөнморьт сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 03 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 635,465.9 мянган төгрөг, татварын бус орлогыг 35,381.1 мянган төгрөг, нийт 670,847.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын орлого 934,453.8 мянган төгрөг, татварын бус орлого 16,387.3 мянган төгрөг, нийт 950,841.1 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 279,994.1 мянган төгрөг буюу 141,7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 480,798.3 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 332,521.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор, 9,892.4 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, нийт 823,211.9 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба 17,947.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 74,300.4 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, нийт 92,247.8 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 430,237.3 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 281,542.3 мянган төгрөгийн, шилжүүлэн авсан 16,535.8 мянган төгрөгийн, нийт 728,315.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 649,051.9 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна

Авлага, өглөгийн талаар:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагаас авах 70,379.2 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 306,723.6 мянган төгрөг, нийт 377,102.8 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн. Нийт авлагын 81,3 хувь буюу 306,723.6 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна. Байгууллагаас авах авлагын 62,288.3 мянган төгрөг нь сумын Эрүүл мэндийн төвийн авлага, 90.9 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн, 8,000.0 мянган төгрөг нь ЗДТГ-ын авлага байна.

Нийт 23,493.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн нь ажилчидтай холбогдсон өглөг 3,419.9 мянган төгрөг, байгууллага, хувь хүмүүстэй холбоотой 20,073.7 мянган төгрөгийн өглөг байна. Байгууллага, хувь хүмүүстэй холбоотой өглөгийн 8,514.8 мянган төгрөгийг Эрүүл мэндийн төвийн, 4,668.6 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн, 6,890.3 мянган төгрөгийг ЗДТГ-ын өглөг эзэлж байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 658,307.8 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд 262.3 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 11,969.8 мянган төгрөг, нийт 670,539.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Бараа материал 292,570.6 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 5,604,851.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	917,522.8	670,539.9	-246,982.9
Авлага	327,747.7	377,102.9	49,355.2
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	213,307.1	292,570.6	79,263.5
Үндсэн хөрөнгө	5,347,833.6	5,604,851.1	257,017.5
Нийт хөрөнгө	6,806,411.2	6,945,064.5	138,653.3

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Өр төлбөр	24,903.1	23,493.6	-1,409.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,781,508.1	6,921,570.9	140,062.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,806,411.2	6,945,064.5	138,653.3

Бараа материалын дансны үлдэгдэл 292,570.6 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 79,263.5 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материалын үлдэгдэл 59,607.4 мянган төгрөг, аж ахуйн материалын үлдэгдэл 14,703.6 мянган төгрөг, бичиг хэргийн материал 9,801.2 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,604,851.1 мянган төгрөг болж 257,017.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгийн зардлаас үерийн далан барих ажлын урьдчилгаанд 260,000.0 мянган төгрөг зарцуулсныг дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэж, тайлагнаснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,921,570.9 мянган төгрөг болж 140,062.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд хүргүүлсэн саналыг шилэн дансны цахим хуудсанд байршуулж, мэдээлээгүй, аудитын явцад төсвийн төслийн талаарх мэдээлэл ирүүлээгүй болно.

Мөнгөнморьт сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн “Төсөв батлах тухай” 03 дугаар тогтоолоор 2021 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 3,064,769.8 мянган төгрөгөөр, мөн Хуралдааны 04 дүгээр тогтоолоор Сум хөгжүүлэх сангийн орлогыг 100,000.0 мянган төгрөгөөр баталсан. Сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолоор 3,188,279.5 мянган төгрөг болгон төсвийг тодотгон баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 2,200,934.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 963,667.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 100,000.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 3,264,602.2 мянган төгрөг төсөвлөгдсөн. Энэ нь сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор батлагдсан төлөвлөгөө 3,188,279.5 мянган төгрөгөөс 76,322.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Тайлант оны зардлын 1,154,836.3 мянган төгрөгийг Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, 1,008,855.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилт, 20,848.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, 90,865.5 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн сангийн санхүүжилт, урьд оны шилжих үлдэгдлээс 889,196.9 мянган төгрөгийг, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 100,000.0 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 2,038,048.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 733,748.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 96,036.7 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 84,553.8 мянган төгрөгийг аймгийн төсөвт, 47,452.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,860,926.5 мянган төгрөг буюу 87,6 хувьтай хэрэгжсэн байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 276,777.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 188,472.1 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 68,140.0 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 19,902.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, 262.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Мөнгөнморьт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС-ийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайланд Хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж, 3,199.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 371,432.6 мянган төгрөгийн албан шаардлага, 1,651.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөн.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК тус сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, сум дундын Ойн анги, эмийн эргэлтийн сан гэсэн 5 санхүүгийн тайланд аудит хийсэн. Аудитаар ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, сум дундын Ойн ангийн санхүүгийн тайланд Зөрчилгүй санал дүгнэлт гаргасан. ЕБС-ийн санхүүгийн тайланд 813.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, 7,029.8 мянган төгрөгийн албан шаардлага, 944,604.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд 332,799.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 34.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, 3,575.7 мянган төгрөгийн албан шаардлага, 262,650.7 мянган төгрөгийн зөвлөмж, сум дундын Ойн анги 287.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Мөнгөнморьт сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 03 дугаар тогтоолоор 2021 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 3,064,769.8 мянган төгрөгөөр, мөн хуралдааны 04 дүгээр тогтоолоор СХС-ийн орлого 100,000.0 мянган төгрөгөөр тус тус баталсан. ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны 03 дугаар тогтоолоор тодотгож, нийт 3,188,279.5 мянган төгрөгөөр батлагдсан. Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг 76,322.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс хугацаа хоцроосон 9, огт байршуулаагүй 2 мэдээлэл байна. Шилэн дансны цахим хуудсанд хугацаандаа байршуулсан ногоон төлөвтэй мэдээллүүд нь шаардлагад бүрэн нийцэхгүй, дутуу, хоосон, байхгүй гэх зэргээр байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 05/113, 05/114 дугаар албан бичгээр ирүүлсэн. Үүнд: Аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу ИТХ-аар төсөв батлахдаа тоон мэдээллийг үнэн зөв мэдээлсэн, шилэн дансны мэдээллийг үнэн зөв гүйцэд байршуулах ажлыг зохион байгуулсан, төсвийн орлогыг нэр төрлөөр биелүүлэх ажил зохиож байна, СХС-ийн зээлийн авлагыг барагдуулах ажлыг зохиож байна гэсэн боловч зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлүүд таслан зогсоогүй, давтагдсаар байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна. Гэвч аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын дагуу сумын хэмжээнд нэгдсэн арга хэмжээ авч ажиллах

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 410,894.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 8,924.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,628.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, 143,934.0 мянган төгрөгийн албан шаардлага, 256,407.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Сумын ИТХ нь санхүүгийн үр дүнгийн тайланд өмнөх оны үзүүлэлтийг зөрүүтэй тайлагнаснаас нийт үр дүнг 3,138.1 мянган төгрөгөөр, Мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн орлого 280.0 мянган төгрөгийг орхигдуулсан байна. Энэ нь Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлан дахь үндсэн цалин, нэмэгдэл, унаа хоолны хөнгөлөлт болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг Санхүү үр дүнгийн тайланд 3,505.9 мянган төгрөгөөр зөрүүтэй, Орлогын гүйцэтгэлийн тайланд төсөвт газрын өөрийн орлогыг батлагдсан төлөвлөгөө 2,000.0 мянган төгрөгийг орхигдуулан нэгтгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 54 дүгээр зүйлийн 54.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Сумын ИТХТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 15-ний 56 дугаар тогтоолоор ИТХ-ын нарийн бичгийн даргад мөнгөн урамшуулал олгохдоо 554.5 мянган төгрөгийг илүү олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Засгийн Газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.6-д “эрх бүхий

этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

Соёлын төвийн эрхлэгч нь сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 24-ний Б/26 дугаар захирамжаар мөнгөн урамшуулал олгохдоо 870.2 мянган төгрөгийг илүү олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5.-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Засгийн Газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

Газрын эрх шилжүүлсэн орлогыг тулгахад 4 газар эзэмших эрхийг бусдад шилжүүлсэн орлогын албан татварыг тооцохдоо худалдах, худалдан авах гэрээний үнэлгээнд тулгуурлаагүй, газрын суурь үнэлгээгээр тооцож, 203.8 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-д “газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого”, 21 дүгээр зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр биелүүлсэн эсэхийг шалгахад Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогын төлөвлөгөө 9,005.0 мянган төгрөгөөр буюу 39,1 хувиар, газрын төлбөрийн орлого 5,747.4 мянган төгрөг буюу 76,8 хувиар, түрээсийн орлого 860.0 мянган төгрөг буюу 95,6 хувиар, нэр зааж ангилаагүй орлого 12,195.2 мянган төгрөг буюу 53,1 хувиар, нийт 4 нэр төрлийн 27,807.6 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг

бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг тооцоо хийж, баталгаажуулсан байдал болон зээлийн хугацаа хэтрэлтийг зээлдэгч бүрээр тулгахад 116,126.4 мянган төгрөгийн хугацаа хэтрэлттэй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй" бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын мэдээтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сумын ИТХ-ын төсөв баталсан тогтоолд газрын төлбөрийн орлогыг татварын бус орлогоор төлөвлөсөн татварын ба татварын бус орлогын 950,841.1 мянган төгрөгийг аймгийн Татварын хэлтсийн ирүүлсэн мэдээгээр 949,989.3 мянган төгрөг буюу 851.8 мянган төгрөгөөр, татварын байцаагчийн ирүүлсэн мэдээг нэр төрлөөр авч үзэхэд 11 нэр төрлийн орлогын дүнг зөрүүтэй мэдээлсэн, Орлогын дансны хуулгатай түүвэрлэн тулгахад ҮХЭХ борлуулсны орлогыг 1,900.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, 4,818.7 мянган төгрөгийн торгуулийн орлогыг нэр зааж ангилаагүй орлогоор, Төсөвт газрын өөрийн орлогоор 2,195.0 мянган төгрөгийг буруу ангилан, нийт 9,765.5 мянган төгрөгийг зөрүүтэй мэдээлж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэ хуульд заасан зарчимд нийцүүлэн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын болон татварын бус орлогын ангилал, тоон мэдээллийг үнэн зөв баталгаажуулж, орлогын мэдээ тайланг санхүүгийн үндсэн баримтад тулгуурлан нэр төрлөөр болон үнийн дүнг зөв ангилан мэдээлж хэвших

2. Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Мөнгөнморьт сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны 03 дугаар тогтоолоор 2021 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 3,188,279.5 мянган төгрөгөөр тодотгож баталсан ба төсвийн гүйцэтгэлийн тайланд 76,322.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэ хуульд заасан зарчимд нийцүүлэн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын болон татварын бус орлогыг үнэн зөв баталж, хяналт тавьж ажиллах

3. Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Сум хөгжүүлэх санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-аас ирүүлсэн сангийн авлагын дүнтэй тулгахад 57,105.1 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн авлагын дүнг ХХААГ-ийн тайлангаас зөрүүтэй мэдээлж буй зөрчлийг арилгаж, зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдлийг зөрүүгүй үнэн зөв тайлагнаж байх.

4. Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Эмийн эргэлтийн сан нь Монгол эм импекс ХХК-д 4,668.5 мянган төгрөгийн өглөгтэй, 200.0 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгэгдээгүй, ОНХС-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Бүрэнцэнгэл ХХК-ний 15,740.3 мянган төгрөгийн, Соёлын төвийн санхүүгийн тайлангийн аудитаар халаалтын зардлын 92,605.6 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгэгдээгүй, нэхэмжлэхийг талбай, хэмжээ нэгжийн үнийг бичилгүйгээр бөөн дүнгээр бичсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5-д “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Эмийн эргэлтийн сангийн өглөгийг барагдуулж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах ба худалдан авалтын цахим баримтыг тухай бүрд авч хэвших

5. Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Засаг даргын шилэн дансны мэдээллийг шалгахад тайлант хугацаанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс хугацаа хоцроосон 9, огт байршуулаагүй 2 мэдээлэл байна. Шилэн дансны цахим хуудсанд хугацаандаа байршуулсан ногоон төлөвтэй мэдээллүүд нь шаардлагад бүрэн нийцэхгүй, дутуу, хоосон, байхгүй гэх зэргээр байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам", санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг үнэн зөв, иж бүрэн мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Засаг дарга	11	410,894.2	2	8,924.0	2	1,628.5	2	143,934.0	5	256,407.7
	ЗДТГ	11	830,328.7	3	455,045.5	2	2,199.0	4	371,432.6	2	1,651.6
	ЕБС	5	961,747.5	1	9,300.0	1	813.2	1	7,029.8	2	944,604.5
	СӨБ	3	333,849.3	1	1,050.0					2	332,799.3
	ЭМТ	5	268,311.1	1	2,050.0	1	34.7	1	3,575.7	2	262,650.7
	Ойн анги	3	287.2			1	287.2	1	0	1	0
	НИЙТ	38	2,806,418.0	8	476,369.5	7	4,962.6	9	525,972.1	14	1,798,113.8

